



**МОНГОЛ
ШУУДАН**



“МОНГОЛ ШУУДАН” ХК

**“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Жич: Өөрийн үнэлгээ



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Нэг. Үнэлгээний зорилго

- 1.1. Энэхүү үнэлгээний зорилго нь “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх, компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшинг сайжруулахад оршино.
- 1.2. “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн зайны үнэлгээг Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-өөс томилогдсон эрх бүхий албан тушаалтан хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлнэ.
- 1.3. Монголын Хөрөнгийн биржийн үнэт цаас гаргагч хариуцсан мэргэжилтэн нь компанийн ирүүлсэн зайны үнэлгээг баримтад үндэслэн хяналтын оноо болон хувь бүхий үнэлгээний нэгдсэн дүнг жилд 2-оос доошгүй удаа тооцно.
- 1.4. Үнэлгээний нэгдсэн дүнг Монголын Хөрөнгийн биржийн үнэт цаасны ангилалд өөрчлөлт оруулах, бүртгэлтэй хувьцаат компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон компанийн засаглалын түвшингийн нэгдсэн судалгаа гаргаж олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор ашиглана.
- 1.5. Монголын Хөрөнгийн биржийн зүгээс “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилт, үнэлгээний нэгдсэн дүнг улирал тутмын эхний долоо хоногт Хороонд хүргүүлж, олон нийтэд мэдээлнэ.

Хоёр. Үнэлгээний бүтэц

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээ нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Өөрийн үнэлгээгээр авсан оноо	Хяналтын оноо	Хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	10		83.3 %
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10		100 %
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	4		66.6 %
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	4		66.6 %
5	Эрсдэлийн удирдлага	8	5		62.5 %
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	4		66.6 %
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	6		75 %
8	Компанийн соёл	6	6		100 %
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9		90 %
Нэгдсэн дүн		72	58		80.5 %

Гурав. Үнэлгээний аргачлал

3.1. Асуулга тус бүрийн хувьд хэрэгжилтийг 0-2 оноогоор үнэлж, хувьд шилжүүлэн үнэлгээг 0-100 хувиар тооцож гаргасан болно. Үүнд:

- Бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан бол 2 оноо;
- Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан бол 1 оноо;
- Үнэлгээ ирүүлээгүй бол 0 оноо.

3.2. Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ. Үүнд:

- Авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
- 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсэж болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
- 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай гэж үзнэ.

**“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

2023.12.28

Бүлэг	НЭГ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна			
№	Зүйл, заалт	Хэрэгжилт	Үнэлгээ	Тайлбар
1	1.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Хэрэгжсэн	2	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд зохицуулалт тусгагдсан. Компанийн засаглалын хүрээнд компанийн дүрмийг шинэчлэх, ТУЗ-ийн хорооны нэршил, чиг үүргийг өөрчлөх, үйл ажиллагааны журмыг 2024 оны 2 дугаар улиралд багтаан шинэчлэхээр төлөвлөн ажиллаж байна.
2	1.2. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.	Хэрэгжсэн	2	ТУЗ-өөс компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэх хөтөлбөр баталсан. Хөтөлбөрийн хүрээнд залгамж халааны бодлогын баримт бичиг батлагдсан, холбогдох хороонд нарийвчилсан журам боловсруулах ажил явагдаж байна.
3	1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн,	1	Компанийн 2023 оны тайланд ТУЗ-ийн гишүүдийн танилцуулга, хараат бус байдал тусгагдсан. 2024 оны тайланд Компанийн үйл ажиллагааны тайлангаас тусад нь ТУЗ-ийн жилийн үйл ажиллагааны тайланг гарган өөрийн цахим хуудсанд байршуулахаар ажиллаж байна.
4	1.4. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.	Хэрэгжсэн	2	Компанийн дүрэмд ТУЗ-ийн дэргэдээ Аудитын, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын болон Стратеги, эрсдэлийн удирдлагын хороотой байхаар заасан бөгөөд хороодын чиг үүргийг тусгасан. Компанийн дүрмийг 2024 онд шинэчлэн баталж хороодын нэршил, чиг үүргийг компанийн тухай хуульд нийцүүлэхээр ажиллаж байна.
5	1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	1	Анх томилогдоход сургалт, танилцуулга хүргэн ажиллаж байгаа. Цаашид ТУЗ-ийн гишүүдэд зориулсан жилийн сургалтын төлөвлөгөө боловсруулан, ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлуулахаар төлөвлөсөн.
6	1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Хэрэгжсэн	2	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажлын тайланд уг асуудал тусгагдсан
		Нийт:	10	

ХОЁР. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ				
7	2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Хэрэгжсэн	2	ТУЗ нь 9 гишүүн (5 ердийн гишүүн, 3 хараат бус гишүүн)-тэй байхаар компанийн дүрмээр зохицуулагдсан.
8	2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	Хэрэгжсэн	2	Аудитын хорооны үйл ажиллагааны журамтай бөгөөд аудитын хорооны даргаар хараат бус гишүүн ажиллаж байна.
9	2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	Хэрэгжсэн	2	Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны журмаар уг асуудлыг зохицуулсан бөгөөд Хорооны нэршил, чиг үүргийг компанийн дүрмийн өөрчлөлтийн хүрээнд шийдвэрлэхээр ажиллаж байна.
10	2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Хэрэгжсэн	2	Нэр дэвшүүлэх хороо нь цалин урамшууллын хороотой нэгдсэн байдлаар Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо гэсэн бүтцээр зохион байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд үйл ажиллагааны журамтай ажиллаж байна. Хорооны нэршил, чиг үүргийг компанийн дүрмийн өөрчлөлтийн хүрээнд шийдвэрлэхээр ажиллаж байна
11	2.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	Хэрэгжсэн	2	Стратеги, эрсдэлийн удирдлагын хороо ажиллаж байгаа бөгөөд үйл ажиллагааны журам, хорооны нэршил, чиг үүргийг компанийн дүрмийн өөрчлөлтийн хүрээнд шийдвэрлэхээр ажиллаж байна
			Нийт:	10
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн байдлыг хангана				
12	3.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	1	Төрийн өмчийн оролцоотой тул Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон холбогдох бусад журмын хүрээнд 3 мэдээллүүдийг ил тод байршуулж байна. Цаашид журмыг шинээр

				боловсруулан батлуулж, мөрдүүлэхээр ажиллаж байна.
13	3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Хэрэгжсэн	2	Засаглалын кодекст заасан засаглалын баримт бичиг, зааврыг компанийн цахим хуудсанд байршуулсан.
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	1	Санхүүгийн тайланг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гарган байгууллагын сайтад байршуулан ажиллаж байна. Цаашид санхүүгийн бус тайланд холбогдох мэдээллүүдийг бүрэн тусган нээлттэй байршуулахаар төлөвлөн ажиллаж байна.
Нийт:			4	
ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана				
15	4.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортай харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.	Хэрэгжсэн	2	Манай байгууллагын хувьд төрийн өмчийн оролцоотой тул Төрийн аудитын тухай хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарч эдгээр асуудлууд холбогдох журмаар зохицуулагдсан байдаг.
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	1	Хөндлөнгийн аудиторын дүгнэлтийг аудитын хорооны дарга ХЭХ-д танилцуулан ажиллаж байгаа бөгөөд цаашид ТУЗ нь дэргэдээ дотоод аудитортай байхаар зорьж 2024 оны бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт оруулан тусгахаар хүлээгдэж байна
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	1	Аудитын бүтэц зохион байгуулалт нь компанийн бүтэц зохион байгуулалтын мэдээлэлд туссан бөгөөд компанийн сайтад нээлттэй байршуулсан. Цаашид ТУЗ нь дэргэдээ дотоод аудитортай байхаар зорьж 2024 оны бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт оруулан тусгахаар хүлээгдэж байна
Нийт:			4	
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина				
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	Хэрэгжсэн	2	ТУЗ-өөс компанийн эрсдэлийн удирдлагын заавар баталсан эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө, үйл ажиллагааны тайланг ТУЗ-д танилцуулах, хянуулах байдлаар ажиллахаар хүлээгдэж байна.

19	5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	Хэрэгжсэн	2	ТУЗ нь дэргэдээ Стратеги, эрсдэлийн удирдлагын хороотой бөгөөд 3 хараат бус гишүүн, 2 ердийн гишүүнээс бүрдсэн бүрэлдэхүүнтэй ажилладаг. Компанийн дүрмийн өөрчлөлтийн хүрээнд холбогдох чиг үүргийн өөрчлөлтийг хийхээр ажиллаж байна.
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Хэрэгжээгүй	0	Компанийн 2024 оны Санхүүгийн бус тайланд холбогдох мэдээллүүдийг бүрэн тусган нээлттэй байршуулахаар төлөвлөн ажиллаж байна.
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	1	ТУЗ-өөс компанийн комплайнсын хяналтын зааврыг баталсан. Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөө батлахдаа компанийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн батлахаар төлөвлөж байгаа бөгөөд энд комплайнсын ажилтны орон тоог оруулж өгөхөөр хүлээгдэж байна. Одоогоор компанийн хуулийн зөвлөх хавсран гүйцэтгэж байна.
Нийт:			5	
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна				
22	6.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	Хэрэгжсэн	2	ТУЗ-ийн цалин болон зардлын төлөвлөгөөг жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн баталдаг бөгөөд 2023 оны цалин, зардлын төсвийг 2023 оны 04 сарын 25-ны хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	1	ТУЗ-өөс компанийн Цалин урамшууллын бодлогын баримт бичгийг баталсан. Батлагдсан бодлогын бичиг баримт болон цалин хөлс тооцох, олгох журмын нийцлийг хангах ажил хүлээгдэж байна.
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	1	ТУЗ-өөс компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний шалгуур үзүүлэлт, гэрээ байгуулах журмыг мөрдөн ажилладаг бөгөөд уг журмыг үйл ажиллагааны тайланд тусгахаар ажиллаж байна.
Нийт:			4	
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ				

25	7.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	1	Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд холбогдох дүрэм, журмыг боловсруулан батлуулахаар ажиллаж байна.
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	1	Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд холбогдох дүрэм, журмыг боловсруулан батлуулахаар ажиллаж байна.
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Хэрэгжсэн	2	Цахим хуудсыг тогтмол ажиллуулж байгаа бөгөөд оролцогч талуудаас холбогдох санал, хүсэлтийг хүлээн авч байна.
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Хэрэгжсэн	2	Компани “Өргөдөл гомдлыг бүртгэх, шилжүүлэх, шийдвэрлэх” журмыг батлан мөрдөн ажиллаж байна. Ажилтнуудын нийгмийн асуудлыг Шуудангийн ажилтны ҮЭ-ийн хороотой байгуулсан хамтын гэрээний хүрээнд зохицуулдаг.
Нийт:			6	
НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ				
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно				
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Хэрэгжсэн	2	Компанийн үнэт зүйлс, алсын харааг 2017 онд тодорхойлсны хүрээнд ажиллаж байгаа бөгөөд ТУЗ-өөс компанийн ёс зүйн дүрмийг баталсан.
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.	Хэрэгжсэн	2	Комплайнсын хяналтын зааварт шүгэл үлээх ажиллагааг тусгасан бөгөөд холбогдох сувгуудын байнгын ажиллагааг хангахаар төлөвлөн ажиллаж байна.
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Хэрэгжсэн	2	Ёс зүйн дүрмийг шинэчлэн баталсан бөгөөд холбогдох агуулгыг тусган ажиллаж байна.
Нийт:			6	
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ				
Компани болон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана				
32	9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр	Хэрэгжсэн	2	Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн хагас жил, улирлын тайланг тогтмол компанийн цахим хуудсанд нээлттэй байршуулдаг.

	дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.			
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Хэрэгжсэн	2	Цахим хуудсыг тогтмол ажиллуулж байгаа бөгөөд оролцогч талуудаас холбогдох санал, хүсэлтийг хүлээн авч байна.
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	Хэрэгжсэн	2	Ковидын нөхцөл байдлаас шалтгаалан 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахимаар хийсэн бөгөөд хуралд оролцогчдыг бүртгэх, хуралдаа оролцох, санал өгөх, саналын хуудсыг нэгтгэх зэрэг бүх ажлыг цахим програмаар шийдвэрлэж амжилттай зохион байгуулсан.
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Хэрэгжсэн	2	Хурлын зар, хэлэлцэх асуудалд санал өгөх ажиллагааг холбогдох хууль, журмын хүрээнд явуулан ажиллаж байна.
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	1	Холбогдох журмыг ТУЗ-өөр хэлэлцэн батлахаар хүлээгдэж байгаа.
		Нийт:	9	